



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 8 дугаар  
сарын 8-ны өдөр

Дугаар 242


Улаанбаатар  
хот

## Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай

Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2, 9.1.1, 9.1.2, Улсын Их Хурлын 2018 оны 73 дугаар тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн тавин нэгээс доошгүй хувийн оролцоотой "Тавантолгой төмөр зам" ХХК-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулсугай.
2. "Монголын төмөр зам" ТӨХК-д олгосон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг цуцалж, мөн зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар "Тавантолгой төмөр зам" ХХК-д олгосугай.
3. "Монголын төмөр зам" ТӨХК-иас Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөлд зарцуулсан хөрөнгөд хөндлөнгийн аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсны үндсэн дээр "Тавантолгой төмөр зам" ХХК-д шилжүүлж, "Монголын төмөр зам" ТӨХК-д хувьцаа эзэмшүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай.
4. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг үргэлжлүүлэхэд шаардагдах хөрөнгийн тодорхой хэсгийг нүүрс урьдчилан борлуулах гэрээ байгуулах замаар санхүүжүүлэхийг "Эрдэнэс Тавантолгой" хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (Г.Нандинжаргал)-д зөвшөөрсүгэй.
5. Энэхүү тогтоолын 4 дүгээр зүйлд тусгагдсан хөрөнгийг "Тавантолгой төмөр зам" ХХК-д оруулах хөрөнгө оруулалтад тооцон "Эрдэнэс Тавантолгой" ХХК-д хувьцаа эзэмшүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Р.Мэргэн), "Эрдэнэс Тавантолгой" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Г.Нандинжаргал)-д тус тус зөвшөөрсүгэй.
6. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн төрд ногдохоос бусад хувьд хөрөнгө оруулах этгээдийг урьдчилгаа төлбөр, боомт ашиглалт, дамжуулан тээвэрлэлт хийх боломжтой гадаадын хөрөнгө оруулагч нараас судлан, хэлэлцээ хийж, үр дүн 2018 онд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нар т даалгасугай.

7. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн техник-эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулж, барилга-угсралтын ажлын явцыг тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэд даалгасугай.



У.ХҮРЭЛСҮХ

Ж.БАТ-ЭРДЭНЭ

